

СОЁМБО МЭДЭЭ

“СОЁМБО” РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.05.05 №47 (47)

ҮЙЛ ЯВДАЛ

ХЭҮК-ТОЙ ХАМТЫН АЖИЛЛАГААГАА ТОДОТГОЛОО



ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг өчигдөр ХЭҮК-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, гишүүн Ж.Хунан нарын албаны хүмүүсийг хүлээн авч уулзаж, хоёр байгууллагын харилцаа, хамтын ажиллагааг тодотголоо.

Уулзалтын эхэнд хошууч генерал Д.Ганзориг “Хоёр байгууллага олон жилийн хугацаанд хамтран ажиллаж, хүний эрхийн чиглэлд нилээдгүй ажил өрнүүлж ирсэн. Цаашид ч гэсэн та бүхний заавар,

зөвлөмжийг цэргийн албаны онцлогтой нийцүүлэн хэрэгжүүлсээр байх болно” гэв. Ж.Хунан “Цэргийн алба хаагчид албан тушаалын зэрэглэл, цолны эрэмбээр захирах, захирагдах ёсыг чанд сахиж, дүрмийн дагуу албан үүргээ гүйцэтгэдэг онцлогтой. Хүний эрхийн үндэсний комисс Зэвсэгт хүчний Жанжин штабтай хамтран 2018 онд Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудад хүний эрхийн сургагч багш бэлтгэсэн. Энэ тогтолцоог цаашид хэвшүүлж,

сургагч багшийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна. Офицер, ахлагч, цэргийн гэрээт болон хугацаат албаны дайчдад хүний эрхийн мэдлэг олгох, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг идэвхжүүлэхэд Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиуд анхаарах хэрэгтэй” гэсэн юм.

Ахлах дэслэгч Д.БОЛОРМАА

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 10	🌧️ -4

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 32	🌧️ 23

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 20	🌧️ 12

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2,845.00	2,856.00
EUR 🇪🇺	3,407.00	3,467.00
CNY 🇨🇳	438.50	441.90
RUB 🇷🇺	37.50	39.10
JPY 🇯🇵	25.84	26.33
KRW 🇰🇷	2.46	2.59

ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 24
2021.05.05.
/ЛХАГВА ГАРАГ/

**ХАВРЫН АДАГ ХАР ЛУУ
САРЫН ЕСӨН УЛААН
ХАРАГЧИН ҮХЭР ӨДӨР**

Үс засуулбал:

Өвчин эмгэг ирнэ.

Наран ургах, шингэх:
05.28-20.10

Барилдлага:

Идэр

Шүтэн барилдлага:

Авахуй

Суудал:

Уул.


Аргын тооллын 5 дугаар сарын 5, Буд гараг. Билгийн тооллын 24, Чөдөр одтой, харагчин үхэр өдөр. Өдрийн наран 5 цаг 28 минутад мандан, 20 цаг 10 минутад жаргана. Тухайн өдөр тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамагй хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эе зэвэ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, хишиг даллага дуудуулах, насан бүтээл хийлгэх, мал арилжих, гэр бүрхэд сайн. Эрдэнийг гадагш өгөхөд муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогосод баруун хойш мөрөө гаргавал зохистой. Зуны уур буух улирал (14 цаг 57 мин)-д эхэлнэ. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ЦАХИМ СУРГАЛТ-ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН СУРГАЛТ

Зэвсэгт хүчний цэргийн сургалт бэлтгэлд цахим сургалт, технологид суурилсан сургалтыг нэвтрүүлэх ажлыг ЗХЖШ-ын Сургалтын бодлого, зохицуулалтын хэлтсээс үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа бөгөөд Та бүхэнд цахим сургалт-технологид суурилсан сургалтын талаар тодорхой ойлголт өгөхийг эрмэлзлээ.

Эрдэмтэн Л.Моори, Криста Галиен нар “Хичээлийн 20 хувьд нь технологи ашиглаж байвал цахим хичээл буюу цахим сургалт болно” хэмээн тодорхойлсон. Цахим сургалтын томъёолол нь компьютерт суурилсан сургалт, вэбд суурилсан сургалт, виртуал сургалт, телевиз, радиогийн сургалт зэргийг агуулах бөгөөд энэ нь суралцагчдад үйлчилгээний өргөн цар хүрээг олгодог. Уг сургалт нь суралцагчдад сургалтын агуулгыг хүргэхдээ бүх төрлийн цахим дамжуулах төхөөрөмж, түүний дотор интернет, хиймэл дагуулийн систем, аудио, видео систем зэргийг ашигладаг ба зайлшгүй ямар нэгэн системээр дамжуулан явуулдаг.

Өнөөдөр Зэвсэгт хүчинд орон зай, цаг хугацаанаас үл хамааран цэргийн сургалт бэлтгэлийг тасралтгүй явуулах боломж бүхий цахим сургалтын системийг бий болгох нь нэн тэргүүнд авч



хэрэгжүүлэх ажил юм. Уг систем нь дараах элементүүдээс бүрдэнэ.

1. МОБАЙЛ АППЛИКЕЙШН

Цахим сургалтын системтэй холбогдож ажилладаг аппликэйшн нь суралцагчид өөрсдийн мобайл төхөөрөмжийг ашиглан онлайнээр суралцах боломжийг олгодог.

ЭНЭХҮҮ АППЛИКЕЙШНИЙГ АШИГЛАН:

- Цахим сургалтын системд бүртгүүлэх, нэвтрэх;

- Хичээлийн контентуудыг үзэх, зарим контентийг офлайн үед үзэх боломжтой байх;
- Хүссэн мэдээлэл, хичээлээ хайх, бусад хэрэглэгчидтэй харилцах;
- Мобайл төхөөрөмжөөс файл байршуулах, хадгалах;
- Өөрт шаардлагатай нэмэлт олон боломжийг ашиглах.

2. ЦАХИМ ХУРЛЫН ӨРӨӨ

Цахим хурлын өрөө нь гадаад харилцаа болон Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагын

хоорондын харилцааг дэмжих, орон зайнаас үл хамааран сургалт, уулзалт, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулахад зориулсан орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

3. МУЛЬТМЕДИА ТАНХИМ

Мультмедиа танхим нь цахим хичээлийг дуу болон дүрс бичлэгийн өндөр чанартай бэлтгэх зорилготой. Тус танхимд цахим хичээлд бэлтгэхээс гадна Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах видео, аудио бичлэг болон байлдааны зэвсэглэл, техникийн видео танилцуулга зэргийг үзүүлэх боломжтой юм. Цахим сургалтын үр дүн, чанар нь зөвхөн хэрэглэгдэхүүний шинж чанараас шалтгаалахгүй бөгөөд суралцагчийн цахим сургалтад бэлэн эсэх, багшийн заах арга зүй, технологийн мэдлэгийн хүчин зүйлийн нэгдлээр илэрхийлэгдэнэ.

ЗХЖШ-ын Сургалтын бодлого, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн, дэд хурандаа А.БАТСҮХ

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН

40.396

ЭДГЭРСЭН

24.333

НАС БАРСАН

126/10

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН

2092 (24)

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ

309

ЭДГЭРСЭН

1759

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 152,534,452

Эдгэрсэн

Нийт: 125,625,642

Нас барсан

Нийт: 3,198,528



ЦАХИМ ШУУДАНД

ХҮНИЙ ХӨГЖИЛ-АНГИЙН ХӨГЖИЛ, ЭЕРГЭЭР ХАНДАЖ ХАМТДАА МАНЛАЙЛЬЯ



Зэвсэгт хүчний 167 дугаар анги

Рот /батареи/, салааны захирагч нартай явуулах “Зөв төлөвшил, зөв хүмүүжил” сэдэвт зөвлөгөөнийг зохион байгууллаа.

Зөвлөгөөнийг нээж ангийн захирагч хэлсэн үгэндээ Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагааны талаар танилцуулж, салаа, салбарын офицеруудын гүйцэтгэх үүргийн талаар зааварчилгаа өгч, туршлага сургамжаасаа хуваалцсан юм. Зөвлөгөөнийг явуулахдаа хөтөлбөрт туссан сэдвийн хүрээнд орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллагуудаас

дэмжлэг авч ажиллав. Үүнд, ХЭҮК-ын Өмнөговь аймаг дахь референт Г.Нарангоо, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын сургагч багш Б.Уянга нар урилгаар оролцон яриа таниулга хийж, хичээл заалаа.

Мөн ҮБХИС-ийн ахисан түвшний сургалтын албаны дарга доктор, дэд профессор, дэд хурандаа Д.Отгонцэцэг цахим сургалт явуулав.

Сургалтын төрсгөлд оролцогчид “Хүний хөгжил-ангийн хөгжил, эергээр хандаж хамтдаа манлайлья” уриалга гаргаж, Зэвсэгт хүчний тэргүүний рот (батареи), салааны захирагч нарын зөвлөгөөнд оролцох бүрэлдэхүүнээ сонгов.

ХЭҮК-ЫН ОРОН НУТАГ ДАХЬ АЖИЛТНУУДАЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ БАЙНА

Зэвсэгт хүчний 336 дугаар анги

Хүний эрхийн боловсрол олгох, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тус анги ХЭҮК-ын орон нутаг дахь ажилтнуудтай 2021 онд хамтран ажиллаж байна.

Тус ажлын хүрээнд рот, батареи, салааны захирагчид, залуу офицер, ахлагч нарт Зэвсэгт хүчин ба хүний эрх, жөндөрийн тухай ойлголт, хүний эрхэд суурилсан харилцаа хандлага, ёс зүй зэрэг сэдэвт сургалт, мэдээлэлд хамруулах, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлж байна.

Түүнчлэн алба хаагчдынхаа гэр бүлийн гишүүдийн хувьд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих



зорилгоор төрийн үйлчилгээний албан тушаалд гэрээгээр ажиллуулах, жөндөрийн тэгш байдлыг хангах,

алба хаагчдынхаа нийгмийн хамгааллыг дээшлүүлэхэд анхаарч ажиллаж байна.

ЗОВОХ ЦАГТ НӨХРИЙН ЧАНАР ТАНИГДАНА

БНЭУ-д цар тахлын нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан Энэтхэгийн ард түмэнд туслах хандивын аянд манай улсын төрийн байгууллага, ард иргэд санаачилгаараа идэвхтэй оролцож байна. Манай хамт

олон ч тус аянд нэгдэж 836.336 төгрөгийг цуглуулж хандивлалаа. Мөн та бүхнийг энэхүү хандивын аянд идэвхтэй хамрагдахыг Зэвсэгт хүчний 336 дугаар ангиас уриалж байна.

Дэслэгч Ч.БОДЫГЭРЭЛ

Сэтгэлийн дэм
ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НЭГЖ, ИРГЭДИЙГ АЯНД НЭГДЭХНИЙГ УРИАЛЖ БАЙНА

Монгол Улс Бүгд Найрамдах Энэтхэг Улстай 1955 оны 12 дугаар сарын 24-ний өдөр дипломат харилцаа тогтоосон тухтай. Сүүлийн жилүүдэд хоёр улсын харилцаа, хамтын ажиллагаа иргэдийн тэмцэл зэвсэг, соёл, боловсролын салбаруудад стратегийн түвшинд хамтын ажиллагааг хөгжүүлж байна.

Дорноговь аймгийн Алтаншарва сумын нутаг дэвсгэрт байрлах “Гарын тос боловсруулах үйлдвэр”, Сайншан суманд Гарын тос боловсруулах үйлдвэрийн ажиллагааг хойно гэх мэт томоохон бүтээн байгуулалтууд Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газрын эмзэгээр хийгдэж байгаа билээ.

“Ковид-19” цар тахлын халдварын эсрэг “AstraZeneca” вакцины буцаатгүй тусламжийг Монгол Улсад хамгийн анх нэгдсэн Энэтхэгийн ара түмэнд туслах “Сэтгэлийн дэм” аянд дорноговьд аюулаас байна.

Монгол Улсад цар тахлын нөхцөл байдал хүндэрсэнтэй ч Бүгд Найрамдах Энэтхэг Улсад цар тахлын улмаас нас баралт маш ихийг түүвшин хүрч, өвчтэй 350 мянга гаруй халдварын тоонолох нэмэгдсэнээр онц аюултай эрсдэлд хүрчээ.

Иймд, Дорноговь аймгийн иргэд, аж ахуйн нэгж байгууллага “Сэтгэлийн дэм” хандивын аянд нэгдэж тусламж үзүүлж байна.

Харьяанд бие биеэр туслах хүмүүсийг биеэ санаж оюун санааны хөрш орон Энэтхэгийн ара түмэндээ сэтгэлийн дэм хайрцаглаа.

ХААН БАНК
ДАНС: 08010073
ХТЛЭЭН АВАЛЧ: ВХУАТ

TDB
ДАНС: 49872328
ХТЛЭЭН АВАЛЧ: ВХУАТ-АН ДОРНОГОВЬ-САЛБАР
ДОЛГОЛРЫН ДАНС: 49872328
ХТЛЭЭН АВАЛЧ: ВХУАТ-АН ДОРНОГОВЬ-САЛБАР

ГЭРИЙН ТУСГААРЛАЛТАД БАЙГАА АЛБА ХААГЧДАД ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭВ


Зэвсэгт хүчний 123 дугаар анги

Аймгийн хэмжээнд бүх нийтийн бэлэн байдлын зэрэг улаан түвшинд шилжсэнтэй холбогдуулан тус анги Ховд аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран ажиллах төлөвлөгөөний дагуу албан үүргээ гүйцэтгэж байгаа болон гэрийн тусгаарлалтад байгаа ангийн офицер, ахлагч, ажилтан, албан хаагчдын ар гэрт хүнсний тусламж үзүүлэв.

Ахмад У.БАТЦЭНГЭЛ



494.847 ИРГЭН ВАКЦИНД БҮРЭН ХАМРАГДААД БАЙНА



Коронавирусийн эсрэг вакцины хоёр тунд хийлгээд хоёр долоо хоногос дээш хугацаа өнгөрсөн бол вакцинд бүрэн хамрагдсан гэж үзнэ.

Дархлаа хүн бүрд харилцан адилгүй хугацаанд тогтдог ч вакцины хоёр дахь тунд хамрагдаад хоёроос гурван долоо хоносон бол тухайн иргэнийг Ковид-19-ийн эсрэг дархлаатай болсон гэж үзэж байна. Энэ сарын 4-ний байдлаар улсын хэмжээнд вакциндаа бүрэн хамрагдсан 494.847 иргэн байгаа бол 1.037.675 иргэн вакцины эхний тунгаа хийлгэжээ.

Дархлаажуулалтад бүрэн хамрагдсан хүмүүс вакцины гэрчилгээгээ <https://vis.health.gov.mn/>

survey/ сайт болон <https://e-mongolia.mn/> сайт руу нэвтэрч авна.

Хэрэв таны мэдээлэл ямар нэгэн алдаатай шивэгдсэн болон вакцинд хамрагдсан мэдээлэл нь ороогүй тохиолдолд харьяа дүүргийн тандалтын албанд холбогдож мэдээллээ засуулах боломжтой

Дүүргүүдийн тандалтын албаны лавлах утас:

- Баянгол дүүрэг- 70120318
- Баянзүрх дүүрэг- 70150056
- Хан-Уул дүүрэг-11-342257, 70049200
- Сүхбаатар дүүрэг- 70116358
- Сонгинохайрхан дүүрэг- 79976000
- Чингэлтэй дүүрэг- 70106677

СЭРЭМЖЛҮҮЛЭГ



Цаг уурын байгууллагаас ирүүлсэн мэдээллээр Улаанбаатар хот орчмоор урсаж буй Туул голын усны түвшин 15 см нэмэгдэж, олон жилийн дундаж түвшингээс 10 см-ээр давсан үерлэх тул шар усны үерийн аюулаас сэрэмжлэхийг анхааруулж байна.

Иймд Туул гол дагуу нутаглаж байгаа болон аялж, салхилж буй иргэдийг үерийн аюулаас болгоомжтой байж, бага насны хүүхдэд тавих анхаарлаа нэмэгдүүлэхийг онцгойлон анхааруулж байна.

Эх сурвалж: ОБЕГ

ШИНЭ ЗЭВСЭГ ТЕХНИК



ТИВ ХООРОНДЫН ШИНЭ БАЛЛИСТИК ПУУЖИН ТУРШИВ

ОХУ-ын Агаар-сансрын цэргийн хүчин Казахстан Улс дахь Сайри-Шаган цэргийн сургуулийн талбайд тив алгасан нисэгч шинэ төрлийн баллистик пуужин амжилттай туршлаа.

Тус улсын БХЯ-ны хэвлэлийн төлөөлөгчийн мэдээлж байгаагаар Агаар-сансрын цэргийн хүчин нь илүү хол зайг туулах чадвартай, газрын болон агаараас эсэргүүцэн хамгаалах боломжтой шинэ пуужингийн туршилтыг ийнхүү амжилттай хийж дуусгасан байна. Туршилтын явцад уг баллистик пуужин нь газар болон агаар дахь целийг маш өндөр цэцгээгээр устгасан аж. Агаар-

сансрын цэргийн хүчний байлдааны бэлэн байдлын дарга, хошууч генерал Сергей Габчук өмнө нь “Красная звезда” сонинд өгсөн ярилцлагынхаа үеэр дурдахдаа тус пуужингийн давуу тал, тактик, техникийн өгөгдөхүүний талаар мэдээлж байв. Мөн тэрээр дараагийн туршилтууд амжилттай болвол ойрын таван жилийн хугацаанд зэвсэглэлд нэвтрүүлэх төлөвлөгөөтэй байгаа талаар нэмж дурдсан юм. Шинэ баллистик пуужин 3000 м/с-ийн хурдтайгаар байг устгах чадалтай бөгөөд энэ нь автоматын сумны нислэгийн хурднаас даруй дөрөв дахин их гэсэн үг юм.

СОЁМБО СОНИН
“Соёмбо” сонин 97 дахь жилдээ хэвлэгдэж байна.
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА, Д.НАНАГДОРЖ

Дарга, ерөнхий редактор Хурандаа **САНЖМЯТАВЫН ТӨМӨРХУЯГ**

Эхийг “Соёмбо” сонины редакцияд бэлтгэв.

*Зар, рекламьг хямд нийтэлнэ.
*Зар, рекламьн үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл бодол сонины нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонины мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс 10018
И-мэйл хаяг: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029